



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 8/45

Ховд

П.Цэцэгсүрэнд чөлөө олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, 80.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.3-ын “а” дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн П.Цэцэгсүрэн нь ар гэрийн гачигдлаар чөлөө хүссэн тул 2021 оны 07 дугаар сарын 19-23-ны өдрийг дуустал хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. П.Цэцэгсүрэнг чөлөөтэй байх хугацааны цалинг бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД